

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийг баталгаажуулах явцад хяналт тавьж байна. - Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 7,3 км урт агаарын шугам, 110/35/10 кВ-ын дэд станцын батлагдсан зураг төслийн төсвийг Эрчим хүчиний яамны эрчим хүчиний хөгжлийн төвийн төсвийн магадлалаар хянуулж магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулахаар хүргүүлсэн. - Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн цахилгаан хангамжийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 4,6 км урт агаарын шугам, 35/10 кВ-ын дэд станцын батлагдсан зураг төслийн төсвийг Эрчим хүчиний яамны эрчим хүчиний хөгжлийн төвийн төсвийн магадлалаар хянуулж магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулахаар хүргүүлсэн. 	90%
2.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.6	Паркийн эзэмшилийн 414 га газрын эргэлтийн цэгүүдийн тэмдэглэгээний нөхцөл байдлыг үзэж, эргэлтийн цэг болон хил хязгаарт хяналт тавьж ажилласан.	100%
3.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.3.1	<ul style="list-style-type: none"> - Зүүн бүсийн аймгуудын удирдлагатай харилцаа холбоо тогтоох ажлын хүрээнд 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Сүхбаатар аймгийн ЗДТГ болон УТП-тай уулзалт зохион байгуулсан. - Уулзалтаар Паркуудын харилцан танилцуулга хийж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож ажиллалаа. 	100%
4.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.5	2021 оны 06 дугаар сард 2019-2020 онуудад үзүүлэх сургалт хийсэн 5 айл өрхийн компост бордооны явцыг ковид-19 цар тахалтай холбоотойгоор цахимаар болон утсаар холбогдон зөвлөгөө өгч ажилласан.	100%
5.		<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн компост бордоог ашигласан “Багануур тохиижилт” байгууллагын төв магистраль автозам дагуух хамгаалалтын зурвасын 110 ш модны ургалтын явцад 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хяналт тавьхад бордооны өгөөж сайн үр дүнтэй байна. 	100%
6.	Засгийн 2020 оны 217 дугаар тогтоол	Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн эхний хагас жилийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 99 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	

7.	Засгийн 2020 оны 218 дугаар тогтоол	Дээд газраас ирсэн тогтоол, захирамж шийдвэрүүдийн хэрэгжилт, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшин, үр дүнг үнэлэх, байгууллагын бодлогын баримт бичгийн хэрэгжилт зэрэгт хяналт шинжилгээ хийх ажлыг 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, ЗГ-ын 218 дугаар тогтоолын 4.14-т заасан холбогдох арга хэмжээг авах саналыг Газрын даргад танилцуулж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	100%
8.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт	Журмын дагуу дараах тайлангуудыг гаргаж холбогдох газарт нь хугацаанд хүргүүлж ажилласан. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт 2. Багануур дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт 3. Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны бичмэл тайлан 4. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн эхний хагас жилийн биелэлт 5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ, дунгийн товчоо, ХШҮ-ний тайлан 6. Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтын II улирлын тайлан 7. Өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн эхний хагас жилийн мэдээ 8. Албан бичиг шийдвэрлэлтийн эхний хагас жилийн мэдээ	100%
9.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - 2021 оны 06 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хариутай 11, хариугүй 7 нийт 18 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.06 - 2021 оны 06 дугаар сарын байдлаар “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 29 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100%	100%
10.	ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол	- 2021 оны 06 дугаар сарын байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 8, цар тахалтай холбоотой 10 мэдээллийг байршуулсан.	100%
11.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	- www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна. - 2021 оны байгууллагын батлагдсан төсвийн хуваарийн дагуу 6 дугаар сарын санхүүгийн орлого зарлагын гүйлгээг хугацаанд нь зохих журмын дагуу хийлгэсэн. - 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Нягтлан бодогч санхүүгийн сургалтанд хамрагдсан. - НЭДТГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 03/1709 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 46 дугаар захирамжийн хүрээнд холбогдох хууль,	100%

		тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан тухай тайланг гарган 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 104 дугаартай албан бичгээр НЭДТГ-т хүргүүлсэн.	
12.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1	<ul style="list-style-type: none"> - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдвартгуйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. - Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна. - Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг зааврын дагуу хэвлэн иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. - "Ковид 19 эрсдэл систем"-ийг бүх албан хаагчдад гар утсандаа суулган ашиглаж байна. - Бүх албан хаагчид коронавирусын эсрэг дархлаажуулалтын 2 дахь тунд хамрагдсан. - 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвартгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдруүдэд мэдээг шинэчлэн НЭДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажиллаж байна. 	100%
НЭМЭЛТ АЖИЛ			
13.	НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 7 хоног тутам НЭДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хүргүүлэн ажиллаж байна.		100%
14.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЭДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна.		100%
15.	Байгууллагын хадгаламжийн сангийн мэдээллийг "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 77 дугаартай албан бичгээр хүргүүлэв.		100%
16.	НЭДТГ-ын 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 08/2191 дугаартай албан бичгийн дагуу 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгууллагын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүд Монгол Улсын Ерөнхий сайд, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн тэргүүн Л.Оюун-Эрдэнийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүдтэй хийх "АЛСЫН ХАРАА-2050 Залуучуудын оролцоо" сэдэвт цахим уулзалтад оролцсон.		100%
17.	НШУҮИГ-ын 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 02/174 дугаартай албан бичгийн дагуу үйлдвэрлэл технологийн паркт байрших үйлдвэр, аж ахуйн нэгжүүд болон паркийн захиргаа хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалт, арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан сургалтад хамрагдах саналыг боловсруулж "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 78 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн.		100%
18.	НЭДТГ-ын 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 03/2195 дугаартай албан бичгийн дагуу Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын хувийн хэргийн материалыг хавсралт маягтын дагуу бүрдүүлж, "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 81 дугаартай албан бичгээр НЭДТГ-ын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлагын тасагт, С.Баяржаргал мэргэжилтний цахим хаягт тус тус хүргүүлсэн.		100%
19.	Монгол Улсын Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27, 30 дугаар зүйлд заасан үүргийн хэрэгжилтийг ханган хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 82 дугаартай албан бичгээр Багануур дүүргийн ИТХ-д хүргүүлсэн.		100%

20.	НШУҮИГ-ын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 02/175 дугаартай албан бичгийн дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай уялдуулан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал, санал байхгүй тухай мэдээллийг "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 80 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн.	100%
21.	"Бүс ба замын улс орнуудад зориулсан Худалдаа аж үйлдвэрийн танхим ба Аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалт" сэдэвт сургалтад хамрагдах 2 ажилтны мэдээллийг 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 84 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т, 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 86 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	100%
22.	НЗДТГ-ын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 08/2471 дугаартай албан бичгийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 99 дүгээр захирамжаар батлагдсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайллан гарган 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 101 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соён гэгээрүүлэх тасагт хүргүүлсэн.	100%
23.	Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газраас цахим уулзалтЫГ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Үйлдвэрлэл, технологийн паркуудтай 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр хамтран зохион байгуулсан. Тус уулзалтаар яамдын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулж төлөвлөгөө гаргаж ажиллахаар НЗД-ын 2021 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/483 дугаар захирамж гарсан. Уг захирамжийн дагын хамтарсан төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан 102 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. Мөн 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дээрх яамд, НЗДТГ, НШУҮИГ, ҮТП-ийн удирдлагууд ҮТП-уудад тулгамдаж байгаа асуудал, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах саналуудын талаар хэлэлсэн цахим уулзалтЫГ зохион байгуулав.	100%
24.	Япон улсын Жайка техник хамтын ажиллагааны төсөлд Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг маягтын дагуу Англи хэл дээр товч танилцуулга байдлаар бэлтгэж НШУҮИГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.	100%
25.	Багануур дүүрэгт Ерөнхий сайд ирж ажиллахтай холбогдуулан паркийн өнөөгийн байдал, цаашдын зорилт, тулгамдсан асуудлын талаар НШУҮИГ болон Багануур дүүргийн ЗДТГ-т тус тус хүргүүлсэн.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА